

## 8.6.6 ҮШББСТ ТӨҮГ нь ТУЗ байхгүй болно.



### ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

**"Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв"**  
төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын  
бүтцийн схем, албан тушаалын жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 9 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 52 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схемийг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай.

- 2.1. Захиргаа, санхүүгийн алба;
- 2.2. Сургалт, дасгалжуулалтын алба;
- 2.3. Үйлчилгээний алба.

3. "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 41 (дөчин нэг) байхаар тогтоосугай.

4. Батлагдсан зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тоог үндэслэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэрт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА


Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
 2022 оны 06 дугаар сарын 16 өдрийн  
 209 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын албан тушаалын жагсаалт, орон тоо

Д/д	Албан тушаал	Орон тоо
1	Захирал	1
<b>Захиргаа, санхүүгийн алба</b>		
1	Албаны дарга	1
2	Хүний нөөц, хууль эрх зүйн асуудал хариуцсан ажилтан	1
3	Мэдээлэл, технологийн ажилтан	1
4	Ерөнхий нягтлан бодогч	1
5	Нягтлан бодогч	2
6	Нярав	2
7	Зэвсгийн нярав	1
8	Бичиг хэргийн ажилтан	1
9	Жолооч	2
<b>Нийт</b>		<b>12</b>
<b>Сургалт, дасгалжуулалтын алба</b>		
1	Албаны дарга	1
2	Гэр бууны дасгалжуулагч	4
3	Урт бууны дасгалжуулагч	4
4	Биатлоны дасгалжуулагч	2
5	Тир зохион байгуулагч	1
<b>Нийт</b>		<b>12</b>
<b>Үйлчилгээний алба</b>		
1	Албаны дарга	1
2	Зохион байгуулалтын ажилтан	1
3	Тогооч	1
4	Зөөгч	1
5	Бэлтгэгч	1
6	Угаагч	1
7	Цахилгаанчин	2
8	Сантехникч	2
9	Үйлчлэгч	4
10	Манаач	1
11	Хамгаалалтын ажилтан	1
<b>Нийт</b>		<b>16</b>
<b>Нийт орон тоо</b>		<b>41</b>

.....000.....



Төрийн өмчийн Сургалтын, дасгалжуулалтын газрын  
2022 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн  
Шийдвэрийн хөрөнгийг хавсралт  
НМБТ ОРОН ТОО: 41

**"ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

